



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 29 өдөр

Дугаар А/551

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", 30 дугаар зүйлийн 30.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2020 оны ээлжит бус XIII хуралдааны 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын шаардлагатай цэгүүдэд хяналтын камер суурилуулах ажилд шаардлагатай зураг төсөлд тусгагдаагүй дугаар танигч сервер 3,522,498 (Гурван сая таван зуун хорин хоёр мянга дөрвөн зуун ерэн найман) төгрөг, радар 4,998,180 (Дөрвөн сая есэн зуун ерэн найман мянга нэг зуун наян) төгрөг, нийт 8,520,678 (Найман сая таван зуун хорин мянга зургаан зуун далан найман) төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны дансны үлдэгдэл, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний жагсаалт, Мөрөн сумын шаардлагатай цэгүүдэд хяналтын камер суурилуулах ажлын зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Азжая/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Базар) нарт зөвшөөрсүгэй.

2. Мөрөн сумын шаардлагатай цэгүүдэд хяналтын камер суурилуулах нэмэлт ажлыг худалдан авах хууль тогтмолжийн дагуу зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд)-д даалгасугай.

3. Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн "Хөрөнгө зарцуулах тухай" А/425 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

4. Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД